



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН  
ХӨГЖЛИЙН САЙД С.ОЮУН  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.08.21 № 03/64 ЧАТ-НАТ/2013/05-НА

Гэрээний гүйцэтгэлд хяналт  
тавьж ажиллах тухай

“Цэвэр агаарын сангийн 2011-2013 оны үйл ажиллагааны хэрэгжилт”-д хийсэн аудитаар БОНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батболд, Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирал Н.Хүрэлсүх, “Хаш техник” ХХК-ийн ерөнхий захирал Д.Бадрах нарын 2013 оны 3 дугаар сарын 29-ны өдөр байгуулсан 830.0 сая төгрөгийн өртөг бүхий “Авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий, утааны тортогжилтын хэмжээг бууруулах төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах гэрээ” бүрэн хэрэгжээгүй, түүний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, суурилуулсан төхөөрөмж үр дүнгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалт, “Хаш техник” ХХК-тай хийсэн гэрээг үндэслэн дараах албан шаардлагыг өгч байна. Үүнд:

1. Гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн гэрээнд заасан барааг бүрэн нийлүүлж, суурилуулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавин, үр дүнг 2014 оны 12 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батболд, Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирал Д.Баасан, “Хаш техник” ХХК-ийн захирал Д.Бадрах нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН

АУДИТОР



Э.УЯНГА